**Батлав**: Дархан-Уул аймгийн Байгаль орчны газрын дарга

______________________________ /Г.БАТБАЯР/

**Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:**

"ДА БАТ ӨРГӨӨ"-ИЙН

Гүйцэтгэх захирал ............................../Д.САРУУЛБИЛЭГ/





**ДАРХАН УУЛ АЙМАГ ХОНГОР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ГАН БЭЛДЭЦ, КАТАНГИ, ГАН БӨМБӨЛГИЙН ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

"ДА БАТ ӨРГӨӨ"ХХК-ийн аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 4280326

Хянасан: БОГ-ын газрыг хэвлий, тусгай хамгаалалттай газар нутаг, БОНБ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн ................................................ А.ЭНХЖИН

**Биелэлтийг тайлагнасан:** "ДА БАТ ӨРГӨӨ " ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН ................................................ У.УРАНБИЛЭГ

2025 он

# Бүлэг 1. Төслийн танилцуулга

## 1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл

| | |
|---|---|
| Төслийн нэр | Ган бэлдэц, катанги, ган бөмбөлөг үйлдвэрлэх үйлдвэр |
| Төсөл хэрэгжүүлэгч | ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Да Бат Өргөө ХХК<br>✓ Улсын бүртгэлийн дугаар: 000194620<br>✓ Регистрийн дугаар: 4280326<br>✓ Хаяг: Дархан-Уул, Дархан, 10-р баг, 5-р хороолол, 1в, 34<br>✓ Утас: +976 9999 0110<br>✓ Цахим хаяг: dabatorgoo@gmail.com |

## 1.2 Төслийн гол зорилго

МУ-ын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт технологийг Монгол улсад нэвтрүүлэн, хаягдал төмөрлөг дахин боловсруулах, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэмүү өртөг шингээх, үйлдвэрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг нэвтрүүлэх, улс орон нутгийн эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах, орон нутгийн ард иргэдийг тогтвортой ажлын байраар хангахад төслийн зорилго оршино.

## 1.3 Төслийн ач холбогдол

Да Бат Өргөө ХХК-ийн ган бэлдэц, катанги, ган бөмбөлөг үйлдвэрлэх үйлдвэр нь хүнд хөнгөн үйлдвэр, зам барилга, эрчим хүч, уул уурхай үйлдвэрүүдийн импортоор авах ган бүтээгдэхүүнийг эх орондоо үйлдвэрлэж гадагшаа чиглэсэн мөнгөн урсгалыг дотоод руу чиглүүлж, түүхий эдийг дахин боловсруулж, капитал шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ач холбогдолтой юм. Тус төсөл хэрэгжиж эхэлснээр улс орны эдийн засаг, хөгжил дэвшил төдийгүй байгаль орчинд ч үнэтэй хувь нэмрээ оруулах төлөвтэй байна.

- Улс орны нийгэм, эдийн засагт хувь нэмэр оруулна. “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан улс орны эдийн засагт чухал хувь нэмэр оруулахуйц томоохон төсөл хөтөлбөрүүд, дэд бүтэц, уул уурхай, барилгын үйлдвэрлэлийн салбаруудын хэрэгжүүлэх төслүүдэд шууд хувь нэмрээ оруулах боломжтой.
- Металл боловсруулах салбарт шинэ техник, технологийг нэвтрүүлнэ. Салбарын хөгжил дэвшлийг түргэтгэх, ханган нийлүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, өрсөлдөөнийг бий болгох улмаар шинэ дэвшилтэт технологиор үйлдвэрлэгдсэн өндөр чанартай бүтээгдэхүүнээр дотоодын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангана.
- Байгаль орчны экологийн тэнцвэрт байдлыг хангахад хувь нэмэр оруулна. Албан бус судалгаагаар жилд 3.5 тэрбум төгрөгийн хаягдал хөнгөн-цагаан түүний хайлшнууд, 2.8 тэрбум төгрөгийн хаягдал өнгөт металл, 120-145 мянган тонн хар төмөр, ширэмний хаягдал бий болдог байна. Төсөл хэрэгжүүлэгч нь жилдээ 53 мянган тонн орчим хаягдал хар металлыг боловсруулснаар байгаль орчныг бохирдуулдаг металл хаягдлуудыг багасгана.

## 1.3 Төслийн хүрээнд 2025 онд хийгдсэн хөрөнгө оруулалт гүйцэтгэсэн бүтээн байгуулалт

Да Бат Өргөө ХХК нь ган бэлдэц, катанги, ган бөмбөлгийн үйлдвэрийг Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт 3 шарын дэд станцын зүүн хойд талд 54.4 га газарт барихаар төлөвлөж барилгын ажлыг 2024 оны 11 сард эхлүүлсэн.

Ган бэлдэц, катанги, ган бөмбөлөг үйлдвэрлэх үйлдвэр жилдээ 50,000 тонн хаягдал хар металл боловсруулж эхний 50,000 тонн жилд ган бэлдэц, 2 дахь жилд 30,000 тонн ган бэлдэц, 20,000 тонн ган бөмбөлөг, 3 дахь жилд 20,000 тонн ган бөмбөлөг, 30,000 тонн катанги үйлдвэрлэнэ.

*Хүснэгт 1 Төслийн талбайн сольбилцлийн цэгүүд*

| № | X | Y |
|---|---|---|
| 1 | 570007.74 | 5472684.42 |
| 2 | 569813.79 | 5472013.51 |
| 3 | 569053.76 | 5472188.35 |
| 4 | 569082.38 | 5472350.53 |
| 5 | 569549.25 | 5472956.23 |
| 6 | 569893.43 | 5472752.19 |




*Зураг № 1 Төслийн* талбайн байршил

## 1.4 Үйлдвэрийн технологийн сонголт

Монгол улсад одоогийн байдлаар ган бөмбөлгийг цутгах, халуунаар цувих, давтах гэсэн үндсэн 3 технологийг ашиглаж байна. Төслийн ТЭЗҮ-д дээрх 3 технологийн харьцуулалтыг хийсний үндсэн дээр бүтээгдэхүүний найрлага, гадаргуугийн цэвэршилт, нарийвчлал сайтай, технологийн усны зарцуулалт бага, үйлдвэрийн явцад үүсэх хий, шингэн, хатуу хог хаягдал бага зэргийг үндэслэн ган бөмбөлгийг цувих технологийг ашиглахаар сонгосон.




*Зураг № 2 Үйлдвэрийн дамжлагын ерөнхий схем*

## 1.5 Үйлдвэрийн явц

Үйлдвэр барихаар төлөвлөсөн газрын нийт хэмжээ нь 54.4 га буюу 544,466 $м^2$ талбайтай. Үүнээс барилга байгууламж 37,150 $м^2$ талбайд төлөвлөгдөж, нийт газрын 7% барилга байгууламж, ногоон байгууламж 30%, явган хүний зам, авто зам 10%, түүхий эдийн агуулахын талбай 10% байхаар төлөвлөсөн.

2024 оны сүүлчээр барилгийн ажлыг идэвхтэй явуулж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 54.4 га талбайг бүрэн хашаажуулж, өөрсдийн хөрөнгөөр 2км сайжруулсан шороон



замыг бий болгосон. Мөн үйлдвэрийн барилгийн ажил болон үйлдвэрийн машин механизм угсралтыг 2025 онд багтаан угсарч дуусах төлөвлөгөөтэй ажилласан.

*Зураг № 3 Үйлдвэрийн батлагдсан зураг төсөл*



*Зураг № 4Үйлдвэрийн өнөөгийн байдал 87%*

# Бүлэг 2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Да Бат Өргөө ХХК-ийн Ган бэлдэц, катанги, ган бөмбөлгийн үйлдвэр төслийн 2023 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу хийж гүйцэтгэсэн. Ган бэлдэц, катанги, ган бөмбөлгийн үйлдвэрийн төслийн БОННҮ тайланд БОМТ-ний 5 жилийн зардлыг 99,960,000 төгрөг зарцуулахаар тооцсон буюу энэ зардлын ихэнх хувийг үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны зардал эзэлж байна. Үүнээс эхний жил зөвхөн барилгын үйл ажиллагаа явуулах үед авах арга хэмжээнд 20,000,000 төгрөг зарцуулах тооцоо гарсан.

## Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Төлөвлөсөн арга хэмжээ | Төсөв /төг/ | Аргачлал, стандарт | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1. Агаар орчин үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах** | | | | | |
| 1 | Үйлдвэрийн барилгын ажлын үед шороон замаар барилгын материал тээвэрлэлт хийх | Барилгын ажлын үед ашиглах түр шороон замын тогтсон маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх дотор | Үйл ажиллагааны зардалд туссан | Агаарын тухай хууль, 9, 11, 23-р зүйл<br>MNS 4585:2007<br>MNS 5365:2004 | *Зураг №-5* |
| 2 | | Барилгын ажлын үед ашиглах түр замын дагуу хурдны хязгаарлалт, маршрутыг заасан тэмдэг тэмдэглэгээ байршуулах | 21*50.000= 1.050.000 | | *Зураг №-6* |
| **2. Газрын гадарга хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ** | | | | | |
| 3 | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд өртөх | Тээвэрлэлтийн олон салаа зам гаргаснаар хөрсөн бүрхэвч талхлагдаж болзошгүй тул замын хөдөлгөөний маршрутыг нарийн гаргаж сайжруулсан шороон зам тавьж , хяналт тавих. | Үйл ажиллагааны зардалд туссан | Газрын тухай хууль<br>MNS:5850:2019 | *Зураг №-6* |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Ахуйн бохирын улмаас ойр орчмын хөрсөн бүрхэвч бохирдох | Барилгын ажилчдын түр ариун цэврийн байгууламжыг стандартын дагуу барьж байгуулах | Дотоод үйл ажиллагааны зардал | | Нийт ажилчдад зориулсан нойл душ барьж цэвэрлэх байгууламжыг Эколос ХХК хийлгүүлсэн. Зураг 8 |
| **Нийт** | | | | | |
| **3.Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ** | | | | | |
| 5 | Нийт ажилчдын усны зохисгүй хэрэглээ | Усыг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах зарчим боловсруулж сануулах арга хэмжээ авч уриалга баннар хийх | Дотоод үйл ажиллагааны зардал | MNS 0900-2018, “Ундны усны чанарын стандарт” | Уриалга, санамжуудыг хийж байршуулав. Зураг 7 |
| 6 | Барилгын ажилчдын унд | Усны зохисгүй хэрэглээг бууруулах, ариг гамтай Ашиглах талаар сургалт орох | Дотоод үйл ажиллагааны зардал | | Нийт ажилчдад сургалт орсон Зураг 9 |
| **4. Амьтанд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ** | | | | | |
| 7 | 14.7 га талбайн өнгөн хөрсийг хуулснаар мэрэгчид, Мөлхөгчид, гэх мэт амьтдын амьдрах орчин сүйдэх | Үйлдвэрийн батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, ашиглах газрын хэмжээг зөрчих, барилга байгууламж барихыг хориглох, үйлдвэрийн талбай тойрсон хашаа татах | Дотоод үйл ажиллагааны зардал | Амьтны тухай хууль | 54,4 га талбайг бүрэн хашаажуулсан *Зураг № 10* |
| | Нийт | | 1.050.000 | | |



*Зураг № 5Үйлдвэрийн хашаан доторх авто замыг цементээр цутгаж тоос шороо босохоос урьдчилан сэргийлсэн*




*Зураг № 6 Дарханы төмөрлөгийн үйлдвэрээс Да бат Өргөө ХХК хүртэл 2км сайжруулсан шороон зам татсан.*





*Зураг № 8 Цэвэрлэх байгууламжын хүчин чадал 20-30 хүн, нийт ажилчдад зориулсан цэвэрхэн тухтай нойл, душ*





*Зураг № 7 Уриалга сануулах баннар тавьсан.*



*Зураг № 9 Нийт ажилчдын сургалт*




*Зураг № 10 54,4 га талбайг 2м өндөр төмөр торон хашаагаар хашаалсан тал амьтан орохоос сэргийлэв.*

## Төслийн орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ

| № | Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Арга хэмжээ | Нийт өртөг /мян.төг/ | Аргачлал стандарт | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үйлдвэрийн хашааг тойруулан ногоон зурвас бий болгох, Салхин нөмөр үүсгэх | 300 ширхэг агч, 700 ширхэг улиас | 3.900.000 | Тэрбум мод үндэсний арга хэмжээ, Байгаль орчны тухай хууль | 2025 оны 5 сард нийт 1000 ширхэг модны суулгац тарьсан. Үүнл 300 агч, 700 ширхэг улиас *Зураг № 11* |
| **Нийт зардал** | | | | 3.900.000 | |



*Зураг № 11 2025 оны 5 сард нийт 1000 ширхэг модны суулгац тарьсан. Үүнл 300 агч, 700 ширхэг хайлаас*

## Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Арга хэмжээ | Нийт өртөг /сая.төг/ | Аргачлал стандарт | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цаг агаарын таагүй нөхцөл байдал үүсэх /салхи, шуурга, үер усны аюул, хэт халалт/ байгалийн аюултай үзэгдэл | ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог хүмүүст дамжуулан анхааруулга өгч байх | Үйл ажиллагааны зардал | ХАБЭА-н тухай хууль | Цаг агаарын мэдээг 7 хоног тутмаар нийт ажилчдын самбарт нийтэлж салхи ихтэй, хур бороо их үед гамшигаас хамгаалах төлөвлөгөөний дагуу аюулын дүн шинжилгээ хийж ажиллав. |
| 2 | Гал түймэр | Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах, гал унтраах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт тогтмол хийх | 1.500.000 | ХАБЭА-н тухай хууль | *Зураг №12* |
| 3 | | Барилгын талбайн ойр орчимд галын аюулын талаар анхааруулга самбар, зохион байгуулалт зэргийг тусган тавих | 1.396.000 | ХАБЭА-н тухай хууль | *Зураг №12* |
| 4 | Үйл ажиллагааны осол гэмтэл | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах | Үйл ажиллагааны зардал | ХАБЭА-н тухай хууль | *Зураг №12* |
| 5 | | Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх | Үйл ажиллагааны зардал | ХАБЭА-н тухай хууль | *Зураг №13* |
| | **Нийт зардал** | | | **2.896.000** | |




*Зураг № 13 Галын иж бүрдэл, Галын анхааруулах самбар зааварчилгаа, Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл өмссөн байдал*


Техник, тоног төхөөрөмж, цахилгаан хүчдэлийн бүр орчмыг цэвэрлэх, тоос шороог арчихдаа анхаарал болгоомжтой байх
Алх, муна зэрэг багаж хэрэгслийг хөдөлгөөнгүй, сугарахгүйгээр сайн ишлэсэн байх
Цахилгаан хөрөө, дрилл, точил зэрэг цахилгаанаар ажилладаг багажтай анхаарал болгоомжтой ажилла

*Ажил дууссаны дараах аюулгүй ажиллагаа:*
Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хүчдэлээс салгаж ажлын талбарыг цэвэрлэж дараа өдрийн ажилд бэлтгэх

Хянасан. ХАБЭА-н ажилтан: Овог нэр.......... албан тушаал .......... .......... он .......... сар ....... өдөр

上班前须知:

*Зураг № 12 Өдөр тутмын АА зааварчилгаа өгсөн бүртгэл*

## Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Нийт өртөг /сая.төг/ | Аргачлал стандарт | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хог хаягдал | Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах зориулалтын хогийн савыг үйлдвэрийн талбайд байршуулах | Үйл ажиллагааны зардал | Хог хаягдлын тухай хууль | Хог хаягдлын талбайг хашаажуулж бэлтгэсэн. *Зураг 15.* |
| 2 | | Хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх | 11 удаа ачилт хийлгүүлсэн 80.000*11= 880.000 | Хог хаягдлын тухай хууль | Зориулалтын талбайд хурааж ачуулдаг. Гэрээ байгуулан ажилласан. *Зураг 14* |
| 3 | | Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх | Үйл ажиллагааны зардал | Хог хаягдлын тухай хууль | Төслийн талбай болон хашаанаас гадна 50м их цэвэрлэгээ 2 өдөр хийсэн Зураг 16 |
| 4 | Аюултай хог хаягдал | Засвар, хяналтын ажлын үеэр хэрэглэсэн тос тосолгооны сав, цэвэрлэгээний бодис, эд анги дугуй зэрэг аюултай хог хаягдал гарсан тохиолдолд ангилан ялгах, мөн хаягдлын хэмжээ 1 тнн хүрсэн тохиолдолд тусгай зөвшөөрөлтэй компаньд өгч хог хаягдлыг зохих журмын дагуу хаях | Үйл ажиллагааны зарагдал | Хог хаягдлын тухай хууль | Төслийн талбайд техникийн тос масло гараагүй шаардлагатай үед дарханы автозасвар дээр очиж үйлчилгээ авсан. |
| | **Нийт зардал** | | | **880.000** | |



*Зураг № 15 Хог хаягдал цуглуулах талбай*



БАТЛАВ:
Хонгор сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-ын дарга
/Д. Ариунболд/

БАТЛАВ:
ДА Бат Өргөө ХХК
...-н Захирал
Д. Саруулбилэг

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ**

2025 оны 01 сарын 15-ны өдөр № 05 Хонгор сум

Энэхүү гэрээг нэг талаас хуулийн этгээдийн 279902 улсын бүртгэлийн дугаар 4293754 регистрийн дугаартай Дархан- Уул аймаг Хонгор сум "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ (цаашид үйлчлэгч ) тал гэх түүнийг төлөөлж Хог хаягдлын үйлчилгээний зохион байгуулагч Гансүх овогтой Нарантуяа нөгөө талаас хуулийн этгээдийн............................ улсын бүртгэлийн дугаар .......................... регистрийн дугаартай .......................................... түүнийг төлөөлж ..........................
Албан тушаалтай............................ овогтой ............................................ (цаашид "Үйлчлүүлэгч") тал гэх нар Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Хот байгуулалтын

*Зураг № 14 Хог хаягдлын гэрээ*



*Зураг № 16 Төслийн талбай болон хашаанаас гадна 50м их цэвэрлэгээ 2 өдөр хийсэн*

## Орчны хяналт шинжилгээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хугацаа давтамж | Нийт өртөг /сая.төг/ | Аргачлал стандарт | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Агаарын чанар<br>• Орчны тоосжилт (PM2.5 , PM10 TSP)<br>• Агаарын температур<br>• Харьцангуй чийг<br>• Гадаад болон дотоод орчны дуу чимээ | Жилд 1 удаа | 250.000 | MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга, | Дархан уул аймгийн цаг уурын газартай гэрээ хийж агаарын тоосжилт, хөрсний еранхий шинжилгээ, хөрсний микрбиологийн шинжилгээ, хаягдал усны шинжилгээг тус бүр хийлгүүлсэн.<br>Зураг 17 |
| 2 | Хөрсний химиболон физик<br>• Ялзмаг<br>• Урвалын орчин (pH)<br>• Карбонат, нитрат, фосфор, кали<br>• Давсжилт<br>• Механик бүрэлдэхүүн<br>• Эзлэхүүн, жин<br>• Хүнд металл | Жилд 1 удаа | 250.000 | | |
| 3 | • Цэвэрлэх байгууламж саарал усанд | Жилд 1 удаа | 300.000 | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний Химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, | |
| **Нийт зардал** | | | | 800.000 | |




*Зураг № 17 Дээж авч буй байдал*

## Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Хариуцсан албан тушаалтан | Нийт өртөг /мянга.төг/ | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр бодлого, журам боловсруулж мөрдөх | БОХАБЭА хэсэг | Дотоод зардал | 2025 онд Хог хаягдлын тухай журам боловсруулан батлуулсан журмын дагуу нийт ажилчдын сургалт арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн. |
| 2 | Орон нутгийн санал Зөвлөмж болох цэцэрлэгийн тохижуулалт | БОХАБЭА хэсэг | 10.000.0 000 | Цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжин шаардлагатай бараа материалын хүлээлгэж өгөв.<br>Зураг № 18 |
| 3 | Жил бүр БОМТ-г батлуулж, биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн БОАЖГ-т хүргүүлэх | БОХАБЭА хэсэг | Дотоод зардал | *Байгаль орчны газар 2025 оны 11 сарын 1-ний дотор илгээсэн.* |
| | **Нийт зардал** | | | 10.000.000 |




*Зураг № 18 Хонгор сумын 32-р цэцэрлэгийн дотор тохижилтод хүлээлгэж өгөв.*

## 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАНГИЙН ЗАРДЛЫН НЭГДСЭН ДҮН

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Нийт зардал /сая.төг/ |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал | 1.050.000 |
| 2 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 3.900.000 |
| 3 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 4 | Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө | 2.896.000 |
| 5 | Хог хаягдлын менежментийн зардал | 880.000 |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал | 800.000 |
| 7 | Удирдлага зохион байгуулалтын зардал | 9.697.696 |
| 8 | Олон нийтэд тайлагнах ажлын зардал | - |
| | **Нийт төсөв** | **19.223.696** |

Хавсралтаар: Ус, агаар хөрсний дээжийн хариу
Компаний гэрчилгээ
Хог хаягдал гэрээ

Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр, байршил: Da Бат Огоо
Огноо: 2015.12.11

| № | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд | Авсан байвал зохих оноо | Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо | | | | | | | | | Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гишүүн 1 | Гишүүн 2 | Гишүүн 3 | Гишүүн 4 | Гишүүн 5 | Гишүүн 6 | Гишүүн 7 | Гишүүн 8 | Гишүүн 9 | | |
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 30 | 30 | 30 | - | 30 | 30 | 25 | 30 | 28 | 29 | | |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/ | 30 | 30 | 30 | - | 30 | 30 | 30 | 30 | 28 | 29.71 | | |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 10 | 10 | 10 | - | 10 | 10 | 10 | 10 | 9 | 9.8 | | |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт | 0 | | 0 | - | | | | | | | | |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт | 0 | | 0 | - | | | | | | | | |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | 10 | 10 | 10 | - | 10 | 10 | 10 | 10 | 9 | 9.8 | | |
| 7 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | 5 | 5 | 5 | - | 5 | 5 | 5 | 5 | 4 | 4.85 | | |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | 5 | 5 | 5 | - | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | | |
| 9 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт | 5 | 5 | 5 | - | 4 | 4 | 5 | 5 | 5 | 4.85 | | |
| 10 | Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | 5 | 5 | 5 | - | 4 | 4 | 5 | 5 | 5 | 4.85 | | |
| | Нийт оноо | 100 | 100 | 100 | - | 98 | 98 | 95 | 100 | 93 | 97.86 | | |

Ажлын хэсгийн дарга:
Дархан-Уул аймгийн БОГ-ын дарга ____________ (Г.Батбаяр)

Нарийн бичгийн дарга:
БОГ-ын газрын хэвлий, тусгай хамгаалалттай
Газар нутаг, БОНБҮнэлгээ хариуцсан мэргэжилтэн ____________ (А.Энхжин)

Хараа ерөө сав газрын захиргаа ……………………… ____________ (…………………)

Цагдаагийн газрын экологийн асуудал хариуцсан эрүүгийн
ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа ____________ (Б.Зам)

БОГ-ын Усны нөөц ашиглалт, хамгаалалт, төрийн бус байгууллага,
судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн ____________ (Я.Батбилэг)

БОГ-ын Орчны бохирдол, хог хаягдал,
химийн хорт бодис хариуцсан мэргэжилтэн ____________ (А.Аззаяа)

ГХБХБГ-ын Газрын удирдлагын хэлтсийн дарга ____________ (Г.Нямдорж)

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн БОШЛ-ийн химийн
технологич инженер ____________ (Э.Сайнзаяа)

Сумын засаг даргын тамгын газрын төлөөлөл

............................................... ____________ (…………………)

Хүлээн зөвшөөрсөн:
............................................. ____________ (…………………)

2025